УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2016 оны 03 сарын 11 өдөр Дугаар А/134 Улаанбаатар хот

Шагнах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалт, Ерөнхий менежерийн шагналын журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 95 жил, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээний баруун түгээх төвийн 10 жилийн ойг тохиолдуулан нийслэл хотын хөгжил, их бүтээн байгуулалтанд идэвх зүтгэл гарган хамт олноо хошуучлан ажиллаж байгаа Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн захирагч хурандаа Н.Ганболд, Захирагчийн орлогч, Ерөнхий инженер дэд хурандаа Ч.Тэгшжаргал, Захирагчийн орлогч, Ар тал хангалтын дарга дэд хурандаа Р.Эрдэнэтогтох, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХК-ийн Баруун түгээх төвийн монтёр Т.Ганболд, С.Ганболд, Үзлэгийн монтёр Л.Нарангэрэл нарыг Хотын Ерөнхий менежерийн "Өргөмжлөл"-өөр тус тус шагнасугай.

2.Өргөмжлөлийг дагалдах мөнгөн шагналыг өөрийн байгууллагын санхүүгээс гарган урамшуулах тухай байгууллагын удирдлагад мэдэгдэхийг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Б.БАДРАЛ

D:\backup_old_pc\Work documents\doc 2016\tushaal 2016.docx

1116300174